



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 07 өдөр

Дугаар А/624

Хэрлэн сум

“Шилдэг багш шалгаруулах”  
уралдаанд хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.7, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны 5 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд аймгийн Засаг даргын нэрэмжит Боловсролын салбарын шилдэг сургууль, цэцэрлэгийн багш шалгаруулах үйл ажиллагааны зардалд 5,000,000 (таван сая) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын эрүүл мэнд, боловсролын салбарын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, арга хэмжээнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д, тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231011480



Аймгийн Засаг даргын 2023  
оны 12 дугаар сарын 07-ны  
..... дугаар захирамжийн хавсралт

### ХӨРӨНГӨ ЗАРЦУУЛАЛТЫН ТООЦОО

№	Зардлын төрөл	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Шүүгч нарын зардал	3	1,500,000	4,500,000
2	Бичиг хэргийн зардал		500,000	500,000
Нийт дүн				5,000,000